

Хөгжмийн зохиолч Ли Ши Шианы “Төгөлдөр хуурын цуврал бүтээл” дэхь “Хангай тэрэгний хажуу дахь үлгэр”-т хийсэн хөгжмийн шинжлэл

Гэрэлтийн Саруул

(Өвөр Монголын Их сургуулийн Урлагийн дээд сургууль, Өвөр Монгол Хөх хот 010010)

Агуулгийн товч: Ли Ши Шиан нь Өвөр Монголын Их сургуулийн Урлагийн дээд сургуулийн профессор, алдарт хөгжимийн зохиолч юм. Хөгжимийн зохиолч Ли Ши Шиан 1998-2001 онуудад бициж туурвисан “Төгөлдөр хуурын цуврал бүтээл” гэх төгөлдөр хуурт зориулсан цуврал байна. Тус өгүүлэл нь Ли Ши Шианы “Төгөлдөр хуурын цуврал бүтээл” дэхь Нэгдүгээр бүлэг болох “Хангай тэрэгний хажуу дахь үлгэр”-т хөгжмийн шинжлэл хийсэн байна.

Зангилгийн үг: Ли Ши Шиан; Хангай тэрэгний хажуу дахь үлгэр; хөгжмийн шинжлэл

Хөгжмийн зохиолч, Урлагийн Дээд сургуулийн декан Ли Ши Шиан нь монгол ардын аялгуунаас сэдэвлэн төгөлдөр хуурт зориулсан 10 бүлэгт 47 цуврал туурвижээ. “Төгөлдөр хуурын цуврал бүтээл”-ын агуулга дорхи мэт:

Нэгдүгээр бүлэг: “Хангай тэрэгний хажуу дахь үлгэр”

- 1.Замын хажуу дахь дэгжин бяцхан буга
- 2.Начин шонхор хун галууны хослол дуу
- 3.Өндөр оргилыг алсаас ширтэх нь
- 4.Ай даа хөөрхий бяцхан туулай
- 5.Шогтой Дүйнхэр да лам

Хоёрдугаар бүлэг: Багачуудын наадмын зураг дүрс

- 1.Бүхчүүд талбайд орж ирсэн нь
- 2.Харалэ зүгтээ ниссэн сум
- 3.Бяцхан морьтны сүр жавхаа
- 4.Сарны гэрэл доорхи овоо
- 5.Түүдэг галын хажуу дахь андай бүжиг

Гуравдугаар бүлэг: Ордосын мөрөөдөл

- 1.Харьд мордуулах дуу
- 2.Баруун уулан харь
- 3.Хундагын бүжиг

4.Архи шалах дуу

5.Дугуй малгай

Дөрөвдүгээр бүлэг:Тал нутгийн зан үйлийн тухай үзэмж

1.Овоон7 тахилга

2.Хуримын дуу бүжиг

3.Цам харайх бүжиг

Тавдугаар бүлэг:Олон янзын хорчин хүүхэнчүүд

1."Цовоо дэгжин Жүй хуар хүүхэн"-F-dur-C-dur

2."Номхон зантай Жинжүүр"-g-moll-B-dur

3."Гутралтай Нуунзаяа"-g-moll

4."Зээдэр Наа-наа"-D-dur

5."Гүн бодлоготой Оюудай"-d-moll

6."Гоё төрсөн Оюунзандан"-D-dur-A-dur

Зургаадугаар бүлэг: Монголын өндөрлөгийн үзэмжит зургийн агуулга

1."Үдшийн туяан доорхи хангай тэргэн жагсаал"-C-dur

2."Зөөлөн салхинд үлээгдэх аргалын утаа"-d-moll

3."Тоглож байгаа хоёр бяцхан унага"-a-moll

4."Элсэн дундах өнчин мод"-a хөг дэвсгэртэй(хөг үгүйсгэл)

5."Эзний хошууны тэмээн зам"-a-moll

Долоодугаар бүлэг:Согтууруулах сайхан ая-Архины дуу

1."Алтан хундага"-c-moll-cis-moll

2."Тэнгэрийн салхи"-B-dur

3."Дөрвөн далай"-d-moll-a-moll

4."Хүдэр"-c-moll

Наймдугаар бүлэг:Чин сэтгэлийн дуу-уртын дуу

1."Дээдсийн сургааль"-Es-dur

2."Дэврүүн найр"-e-moll-G-dur

3."Халил"-e-moll

4."Гунирхал"-d-moll

Есдүгээр бүлэг:Салшгүй сэтгэлгээ-Нутгийн мөрөөдөл

- 1."Шар хад"-Es-dur-C-dur
- 2."Дааяа бөөр"-g-moll
- 3."Хун галуу"-e-moll
- 4."Уулын нуруун дээр"-d-moll
- 5."Мүсэрэй"-D-dur

Аравдугаар бүлэг:Үлгэрийн тайлбар

- 1.Эхлэл
- 2.Захиа мэдүүлэх
- 3.Аян дайн
- 4.Тахилга тахих
- 5.Ялалт

Судлагч миний бие Ли Ши Шианы бүх бүтээлд судлагаа хийсэнгүй, харин бүлэг бүрээс тодорхой онцлогтой аязуудыг төлөөлүүлэн сонгон авч түүнийхээ талаар дэлгэрүүлэн сулдлах зарчмыг баримтлав.

Нэгдүгээр бүлэг: "Хангай тэрэгний хажуу дахь үлгэр"

- 1.Замын хажуу дахь дэгжин бяцхан буга-B үи
- 2.Начин шонхор хун галууны хослол дуу-D же
- 3.Өндөр оргилыг алсаас ширтэх нь-g moll
- 4.Ай даа хөөрхий бяцхан туулай-G гүн
- 5.Шогтой Дүйнхэр да лам-D үи гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

"Замын хажуу дахь дэгжин бяцхан буга" дууны үг

Замын захын загзгар хайлсыг цавчивч зангаараа

Жаахан багын бидэн хоёрыг зайдуулавч зангаараа

Хад байгаад хагарахын оронд хайрга болоод шуурсан нь дээр

Ханилж байгаад салахын оронд харин ердөө танихгүй нь дээр.

"Замын хажуу дахь дэгжин бяцхан буга" дууны эх хувилбарын нот: [1]



“Замын хажуу дахь дэгжин бяцхан буга” дууг зохиогч уг аялгууг бага зэрэг хувиргаж, аялгууны сэдлээс санаа авсан төгсгөл хэсгийг нэмж найруулжээ.

“Начин шонхор болон хун галуу” дууны эрэлт:

Тус дуу нь Хорчин нутгийн онцлогтой нэн эртний ан авалж байсан үеийн дуу. Амьтныг хүнчлэн илэрхийлж, хүний бодол сэтгэлийг харуулсан. Начин шувуу болон хун галууг хослол дууны шинж маягаар зүйрлэн илэрхийлсэн байна.

“Начин шонхор болон хун галуу” дууны үг:


Туурын голын хөвөөнд өө зэ хө зэ

Нуур дүүрэн хун галуутай зэ

Нуур дүүрэн хунгийн дунд зэ хө зэ

Хун цагаан галуу хөөрхий дө

“Начин шонхор болон хун галуу” дууны эх хувилбарын нот^[2]





“Начин шонхор болон хун галуу” дууны аялгууг зохиогч шууд авч хэрэглэжээ.

“Ай даа хөөрхий бяцхан туулай” дууны эрэлт

Тус дуу нь Хөлөнбуйр нутгийн онцлогийг илэрхийлсэн буриад ардын ан авлалын тухай дуу юм. Монгол үндэстэн эртнээс ан авлаж амьдарч байсан болохоор ардын дуунууд нь ан авлалын сэдэвтэй холбоотой байдаг. Ангийн дуу нь мал аж ахуйн орны дуунаас эрт бий болсон ба ан авлагчид туулайг бие бага, арьс нь нимгэн гэж голдог бөгөөд туулайг түрүүлж авласан хүнийг их ан олохын бэлгэ тэмдэг гэж үздэг байсан байна.

“Ай даа хөөрхий бяцхан туулай” дууны үг:

Бөн бөн гүйдэлтэй бүжинхэй туулай

Бутаа тойроод бөншиж гүйнэм байна

Ар ар шилдээн аятайхан хэвтлээ дээ

Аргалчин, хоньчин авлахад айгаад бослоо байна

“Ай даа хөөрхий бяцхан туулай” дууны эх хувилбарын нот [3]



“Ай даа хөөрхий бяцхан туулай” дууны аялгууг зохиогч тэр хэвээр нь авч найруулсан байна.

“Дүйгхэр да лам”болон “Хайчин шувуу”дуу нь Зүүн орны нутгийн ард түмний дунд ихэд түгээмэл тархсан дуу бөгөөд эхнийх нь хөнгөн,шоглонгуй дүрийг илэрхийлдэг.энэ хэсгээс“Дүйгхэр да лам”дуунаас эшилсэн бүтээлийг задлаж үзье.

“Дүйгхэр да лам”дууны эрэлтийг авч үзвэл:

Бараг XX зууны 30-аад оны үеэр Дархан хошууны Бао Лун Шаны Манитын сүмийн лам Дүйнхэр болон энэ сүмээс ойролцоо байсан Булагхаяг гэсэн айлын хүүхэн Танхуар хоёрын янаглаж ааёсан үнэн үлгэрээс үүссэн дуу болно.

“Дүйгхэр да лам”дууныүг

Урт сайхан гаансдайгаа нааш аа өгдөө хө

Үнэр сайтай хайнен тамхиа унгасгаад барьяа хө

Урдын нөхөр Танхуар чамтай уулзсанаас

Уушиг зүрхний хоёрхон үгээ хэлэлцэн сууяа хө

⁵ “Хорчин ардын дуу” 1983, Тун Лео хот

“Дүйгхэр да лам”дууны аялгууг найруулахдаа айзам бүрт за такттай болгон өөрчилжээ. Учир нь уг дууны төрхийг тодорхойлохын тулд ийнхүү зохиомжилсон хэмээн үзэж байна.

“Дүйгхэр да лам”дууны эх хувилбарын нотыг сийрүүлбэл:

Нотны жиш

“Дүйгхэр да лам”[4]



Энэхүү дуу нь 4 тэгш тухайлбалтай жирийн дууны бүтэцтэй, харин 7-р айзамд гарч ирэх цэгтэй хэмнэл, 9-р айзмын синкопийг эс тооцвол ерөнхийдээ жигд хэмнэлтэй, ре минорт бичигдсэн байна. Цомнолын хувьд авч үзвэл ре-фа-соль-ля-до гэсэн таван эгшигтийн D үи цомнол язгуурт нь байгааг төвөггүй харж болно.



Мөн мөчлөг бүрийн хооронд гарч байгаа нь тухайн нутгийн аялгууны онцлог юм. Өөрөөр хэлбэл байгалийн байдал, уул ус, ахуй орчны байдалтай зохицсон байна.

Аялгуу аливаа хөгжмийн бүтээлийн амин сүнс юм. “Аялгуугүй хөгжим хөгжим биш” гэж Оросын нэрт хөгжмийн зохиолч М.Глинка уулга алдаж байсан удаатай.

Хөгжмийн бүтээлийн үзэл санаа, хүний сэтгэл хөдөлгөх агуулга юуны түрүү аялгуугаар дамжиж илэрнэ. Тэр дууны аялгуу уран сайхны төгс дүр болж чаддаг байна.

Хөгжмийн аливаа зохиол бүтээл юуны түрүү аялгуугаараа танигддаг.

Манай үндэсний уламжлалт болон зохиолын олон сайхан дуу дуулагдсаар байдгийн учир нь монгол хүний сэтгэлгээний онцлог, сэтгэлийн учгийг шингээсэн тансаг сайхан аялгуундаа оршино. Хөгжмийн зохиолч энэхүү дууг уг эхээр нь ягчлан давтаагүй боловч тухайлбараас нь эшилсэн нь харагдаж байна.

Харин нэрний ховьд хөгжмийн зохиолч зарим дууны нэрийг өөрийн сэтгэмжээр өөрчилсөн тал ажиглагдаж байна. Энд жишээлбэл “Дүйгхэр да лам”

хэмээх дууны нэрийг “Шогтой Дүйгхэр да лам” хэмээн өөрчилжээ. Энэхүү дууг зохиогч хэрхэн найруулсаныг харъя.

Нотны жишээ

“Шогтой Дүйгхэр да лам”



Мөн үндсэн дэвгэр хөгийг өөрчлөөгүй байх ба бүтээцийн ерөнхий зарчим нь адил. Өөрөөр хэлбэл хэлбэр талаас нь авч үзвэл жирийн 2хэсэгтэй байна гэсэн үг. Харин төгсгөлд нь 7 айкмын кода нэмж оруулсан нь хөгжмийн зохиолчийн өөрийн санаа бөгөөд төгс дуусгавар хийжээ. Үнэндээ дууны угийн байдал нь онцын өөрчлөлтгүйгээр дан хөгжмийн бүтээл болсон гэхэд болно. Харин хэмнэлийн хувьд наймтын зогсоцуудыг ашигласнаар дуунаасаа илүү хөнгөмсөг, хошин дүрийг илэрхийлэх маягтай болгожээ.

Зүүлт

- [1] “Ордосын ардын дуу” 1981, Хөх хот.
- [2] “Хорчин ардын дуу” 1983, Тун Лео хот.
- [3] “Хорчин ардын дуу” 1983, Тун Лео хот.
- [4] “Монгол үндэстний 500 ардын дуу” 1978, Тун Лео хот.

Зохиогчийн товч танилцуулга: Гэрэлтийн Саруул (1972-) ,эмэгтэй,Монгол үндэстн, Өвөр Монголын Хорчин баруун гарууи дундад хушууны хүн. Өвөр Монголын Их сургуулийн Урлагийн дээд сургуулийн багш,төгөлдөр хуурын хөгжмийн талаар голчлон судлалж буй.

Тус эх бичгийг 2011-02-15-д олов.